



## БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Тус газар 2025 оныг “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын өрийг барагдуулах жил” болгон зарласантай холбоотой, Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ажлаа төлөвлөн, дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хянан шалгах, хуримтлалын сангийн удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд биелүүлэх, хуримтлагдсан өр, авлагыг барагдуулах, тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь олгох, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд даатгуулагчдад ил тод, шуурхай чирэгдэлгүй хүргэх, нийгмийн даатгалын тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан тогтоол, тушаал, дүрэм, заавар, журам, аргачлалыг иргэдэд түгээн сурталчлах, тэдэнд тайлбарлан таниулах, зөвлөгөө өгөх, дэмжлэг тусалцаа үзүүлэх замаар даатгалын хамралтыг нэмэгдүүлж, ажилтан, албан хаагчдын мэдлэг, чадварыг сайжруулах, мэргэшүүлэх сургалтанд хамруулахад чиглүүлж дараах ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

### НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ

#### *Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд*

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар зөвлөмж-10, журам-1, тушаал-14, заавар-8, аргачлал-1, шийдвэр-1, чиглэл-11 нийт 46 заавар, чиглэл, зөвлөмжийг нэгжүүдэд танилцуулан хэрэгжилтийн тайлан, мэдээг гаргуулан, нэгтгэн дээд газарт хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01/47 тоот Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг зөвлөмжийг мөрдөн ажиллаж 2025 оны 1-6 сард 1721 тэтгэврийн материал, 902 тэтгэмжийг хүлээн авч, 7354 сайн дурын даатгалын гэрээг шинээр болон, шинэчлэн байгуулж ажилласан. Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэдээс 604 эмэгтэй даатгуулагчийн төрүүлсэн хүүхдийг ажилласан жилд оруулан тооцож тэтгэврийг тогтоож олгосон байна. Ажилгүйдлийн даатгалыг тасралтгүй 9 сар шимтгэл төлж эрх хуулийн дагуу 1158 тэтгэмжийн хүсэлт авч шинэчлэсэн хувь, хэмжээгээр бодож олгосон байна. Хөдөлмөрийн чадвараа түр алдсны тэтгэмжийн хувь хэмжээгээр 2701 даатгуулагчдад шинэчлэсэн хувь, хэмжээгээр бодож олгосон байна. Цэргийн албан хаагчийн жирэмсэн амаржсаны 40, хөдөлмөрийн чадвараа алдсны 47 хүсэлтийг хянан баталгаажуулсан байна. 2 цэргийн албан хаагчийн ажилгүйдлийн тэтгэмжийг хуулийн дагуу хариулт өгч цуцалсан байна.

- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 02 дугаар сарын 19-ний өдрийн А/38 тоот тушаалаар 2025 оныг Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийг өрийг бууруулах жил болгон зарласантай холбоотойгоор нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан, иргэдэд төрийн үйлчилгээг ойр болгох үүднээс газрын даргын гаргасан дэд төлөвлөгөөнд тусгагдсан хуваарийн дагуу зах, худалдааны төв, хороодоор ажиллалаа. Энэ ажлын хүрээнд нийгмийн даатгалын аппликэйшний зөвлөгөө, мэдээлэл солих 50, тэтгэврийн зөвлөгөө 283, тэтгэмжийн зөвлөгөө 133, сайн дурын даатгалын зөвлөгөө 398 даатгуулагчдад нийт 864 хүнд хүрэн, зөвлөгөө өгч ажиллалаа. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Нийгмийн даатгалын ерөнхий газар, болон тус газрын пэйжид тавьж байгаа мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээн ажилласан.

- Ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг сайжруулах, ажил эрчимжүүлэх тухай 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэн үйлчилгээ авахаар хандсан иргэн, даатгуулагч, тэтгэвэр авагч (үйлчлүүлэгч) нарт үйлчилгээг бүрэн гүйцэд, чанартай, шуурхай, хүнд сурталгүй, тэгш хүртээмжтэй үзүүлэх, үйлчилгээний талаар ойлгомжтой, тодорхой танилцуулах, зөвлөн туслах, үйлчлүүлэгчдийг чирэгдүүлэхгүй байхад анхааран ажлын цагийн хоцрогдолгүй, түргэн шуурхай үйлчилж байна.

- Архив, албан хэрэг хөтлөлтийн талаархи зөвлөмжийг уншиж танилцан, 2025 оны албан бичиг, тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмж хүлээн авсан тухай анхан шатны бүртгэл холбогдох баримт бичгийг заавар зөвлөмжийн дагуу бүртгэл үйлдэн ажиллаж байна.

- Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын 2025 оны 05 дугаар сарын 02-ны 04/1091 тоот зөвлөмжид орсон

-Мал тооллогын бүртгэл “А” дансны талаар,

-Түгээгч” буюу “нефть хангамжийн операторчин”, “галч” ажил мэргэжлийг хөдөлмөрийн хортой, хүнд нөхцөлд хамааруулах эсэх талаар

- -Төрийн албан хаагчийн давхар ажил эрхлэлтийн талаархи зөвлөмжийг уншиж танилцан, ажилдаа мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн зөвлөмжийн хүрээнд нийт 72 тэтгэврийг нөхцлөөр тогтоосон.

- НДЕГ-ын даргын 2025.05.02-ны 04/1094 тоот Зөвлөмж хүргүүлэх тухай, зэрэг дээд газраас ирүүлсэн заавар зөвлөмжийн хүрээнд ОХУ-ын тэтгэвэр авагч иргэдийн регистрийн дугаарыг мэдээллийн санд YUD /ЮД/ регистрээр 87 тэтгэвэр авагчийг бүртгэн баталгаажуулж тэтгэврийг олгож байна.

- Нийгмийн даатгалын шинэчилсэн хууль 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан 72 ба 84 сараар 2019 оноос 2024 оны хооронд өндөр насны болон хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэвэр тогтоолгосон 6 иргэний өргөдлийг хүлээн авч 60 сараар өөрчлөн тогтоож хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тэтгэврийн тусгай зохицуулалт буюу нас барсан тэтгэвэр авагчийн эхнэр/ нөхөр-ийн өндөр насны тэтгэврийн 20 хувиар нэмэгдүүлэх хуулийн дагуу 105 тэтгэвэр авагчдад тэтгэврийн өв олгосон байна. Сайн дураар даатгуулагч малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг төрөөс хариуцах хуулийн дагуу 9 малчинг даатгуулагчийн сайн дурын даатгалд хамруулсан. Байнгын асаргаа шаардлагатай хүүхдээ асарч байгаа эх /эцэг/-ийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцах хуулийн дагуу 164 даатгуулагчийг хамруулсан.

- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01-р сарын 13-ны өдрийн 01/84 тоот “2025 оны төсвийн хуваарь хүргүүлэх тухай” албан бичиг, НДЕГ-ын даргын 2025 оны 3-р сарын 11-ний өдрийн “Үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” А/49 дүгээр тушаал, 2025.05.21-ний өдрийн 01/1279 тоот тушаалаар төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан бөгөөд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасныг баримтлан төсвийн сахилга батыг ханган ажиллаж байна.

- 2025 оны 1-р сарын 30-ны өдрийн “Төрийн өмчийн эзэмшүүлэх гэрээний биелэлт ирүүлэх тухай” 07/224 тоот албан бичгийн дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны 64 дүгээр тэмдэглэлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө, тус газрын даргын баталсан удирдамжийн дагуу Баянзүрх дүүргийн



нийгмийн даатгалын газрын төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалт, газар эзэмшил, ашиглалт, баталгаажуулалтын үйл ажиллагаанд Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн дарга, санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч Ц.Түвшинзаяа, мэргэжилтэн, санхүүгийн хяналт шалгалтын Улсын байцаагч Ч.Батчимэг, мэргэжилтэн Я.Эрдэнэбаатар нар баримт /систем/-ын шалгалт хийж дүгнэлт гаргасан.

- 2025 оны 2-р сарын 05-ны өдрийн “Шилэн дансны зөвлөмж хүргүүлэх тухай” 02/262 тоот албан бичгийн дагуу газрын хэмжээний мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлэх бүх мэдээллийг оруулан тайлагнаж шилэн дансанд байршуулан ажиллаж байна.


- 2025 оны 3-р сарын 29-ны өдрийн “Мэдээлэл хүргүүлэх тухай” 01/707 тоот албан бичиг, 2025 оны 4-р сарын 03-ны өдрийн “Үндсэн хөрөнгө шилжүүлэх, актлах, ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэх жагсаалт” ирүүлэх тухай 01/767 тоот албан бичгүүдийн хэрэгжилтийг 100% чанарын шаардлага, үнэн зөв байдлыг ханган ажилласан.

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн нарийвчилсан хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийн хүрээнд: НДЕГ-ын 2025 оны 01-р сарын 13-ны өдрийн №01/84 тоот “2025 оны төсвийн хуваарь хүргүүлэх тухай” албан бичиг, НДЕГ-ын даргын 2025 оны 01-р сарын 06-ны өдрийн №А/02 дугаар “Үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн хуваарь батлах тухай” тушаалаар батлагдсан 2025 оны батлагдсан төсөвтэй танилцан байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах зорилгоор бүлгийн дүнд багтаан эдийн засгийн ангиллаар нь зарцуулан ажилласан. 2025 оны эхэнд 3,411,800 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй байсан ба батлагдсан төсөв хүрэлцэхгүй болон зардал хооронд шилжүүлэх саналыг холбогдох тооцоо, судалгаа, тайлбарын хамт НДЕГ-т 2025 оны 3-р сарын 20, 4-р сарын 16, 5-р сарын 24, 6-р сарын 4-ний өдөр 4 удаа хүргүүлсэн. Батлагдсан төсвийн санхүүжилт 1,245,600 сая төгрөг 100% хийгдсэн. Үүнээс 1,148,800 сая төгрөг буюу 92,2% хувийн зардлын гүйцэтгэлтэйгээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан. Төрийн Хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан.

## Ажил олгогч, иргэд, даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулах талаар:


Нийгмийн даатгалын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх, үйлчилгээний чанарт үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор тайлант оны эхний хагас жилд хоёр удаагийн сэтгэл ханамжийн судалгааг авч ажилласан байна.

Тус судалгааны үр дүнгээр 2025 оны 1, 2 дугаар улиралд иргэд, даатгуулагчдаас нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар 10 асуултаас бүрдэх сэтгэл ханамжийн судалгааг авч, нэгтгэн дүгнэлээ.





Эхний хагас жилд 360 даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгааг авч үр дүнг нэгтгэж ажилсан. Судалгаанд хамрагдсан оролцогчдын цахимаар 230 цаасаар 130 хүн хамрагдаж судалгааны үр дүнд олон нийт үйлчилгээний чанарт хангалттай сайн үнэлгээ өгсөн 52% сайн үнэлгээг 36% Бүрэн гүйцэд авч чадаагүй 16%

гэж өгсөн бөгөөд цаашид:



Үйлчилгээний чанарыг сайжруулах, Цахим үйлчилгээний талаарх мэдээллийг түгээх ажлыг эрчимжүүлэх, Иргэдийн дунд хууль тогтоомжийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, тал дээр анхаарч ажиллах шаардлагатай гэсэн санал, хүсэлтүүд гарсан тул эдгээрийг тусган Үйлчилгээний чанарыг сайжруулах, цахим системийг илүү ойлгомжтой байлгах, Иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх сар бүрийн цахим сургалт тогтмол зохион байгуулах шаардлагатай нь тодорхойлогдож байна.



Судалгаанд хамрагсдыг хүйсийн байдлаар авч үзвэл

89 буюу 44,5 % нь

Эрэгтэйчүүд



121 буюу 60,5 % нь


Эмэгтэйчүүд



## ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТООН МЭДЭЭ, ҮЗҮҮЛЭЛТҮҮД

#### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ /тэрбумаар /




хугацаанд нь олгох, өр авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах ажлын талаар



Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын даргын 2023.12.27-ны өдрийн тушаалаар 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нийгмийн даатгалын сангийн төвлөрсөн орлогын дансны үлдэгдлийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр төвлөрүүлнэ гэсний дагуу 5 сарын 31-ний байдлаар нийт 197,026,05 сая төгрөг төвлөрүүлэн ажилласан.

Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөө болон орж ирсэн санхүүжилтийн дагуу зарцуулж байгаа бөгөөд эхний 6 сарын гүйцэтгэлээр тэтгэврийн сангийн төлөвлөгөө 288923,34 сая төгрөг, хүлээгдэж буй гүйцэтгэл 291487,56 сая төгрөг буюу 2564,22 сая төгрөгийн хэтрэлттэй байна. Тэтгэмжийн даатгалын сангийн төлөвлөгөө 18'893,21 сая төгрөг, хүлээгдэж буй гүйцэтгэл нь 17,0713,40 сая төгрөг байх бөгөөд 1179,81 сая төгрөгийн хэмнэлттэй байна. ҮОМШӨ-ний даатгалын сангийн төлөвлөгөө 2366,92 сая төгрөг, хүлээгдэж буй гүйцэтгэл нь 2111,64 сая төгрөг байгаа бөгөөд 255,28 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан. Мөн ажилгүйдлийн даатгалын сангийн төлөвлөгөө 14302,8 сая төгрөг, хүлээгдэж буй гүйцэтгэл нь 14523,59 сая төгрөг зарцуулсан бөгөөд 220,79 сая төгрөгийн хэтрэлттэй байна.



2025 оны 05 дугаар сарын 31-ний байдлаар байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/03 дугаар “Үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн хуваарь батлах тухай” тушаалын дагуу бүлгийн дүнд багтаан эдийн засгийн ангиллаар нь зарцуулж нийт санхүүжилт 1,245.6 тэрбум төгрөгийн төсөв батлагдсанаас 05 дугаар сарын 31-ний байдлаар гүйцэтгэлээр нийт-1,148.8 тэрбум төгрөг, үүнээс; цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 956.3 сая төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 119.5 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 19.5 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 7.8 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 1.3 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр болон бараа үйлчилгээний бусад зардал, харуул хамгаалалтын зардал, өмгөөлөл хуулийн зөвлөхийн зардалд 3.6 сая төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардалд 3.0 сая төгрөг, зөвлөл, хороо комиссын гишүүдийн зардалд 40.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. 2025 оны 5-р сарын 31-ний байдлаар төсөв нэмэгдүүлэх болон зардал хооронд шилжүүлэх саналын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 03-р сарын 11-ний өдрийн А/49 дүгээр тушаал, 2025 оны 05-р сарын 06-ны өдрийн А/129 дүгээр тушаалуудаар

батлагдсан төсөвт нийт 2 удаа өөрчлөлт хийгдсэн. Төсвийн хэмнэлтийн хуулийн дагуу зардлыг 7,8%-иар хэмнэж, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэн ажилласан.

Төсвийн тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулиудад нийцүүлэн урсгал зардлын төсвийн гүйцэтгэл, өр авлагын сарын мэдээг сар бүрийн эхний ажлын өдөр үнэн зөв гаргаж, хуулийн хугацаанд нь нийт 6 удаа Нийгмийн даатгалын ерөнхий газарт хянуулж хүргүүлж баталгаажуулсан. Нийгмийн даатгалын шинэ систем программаар 2024 оны жилийн эцсийн тайланг гаргаж НДЕГ болон Сангийн яамны тайлангийн системд оруулан баталгаажуулсан. Мөн Төсвийн гүйцэтгэлийн 1,2-р улирлын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж НДЕГ-т хянуулан хүргүүлж баталгаажуулан ажиллах тушаалтай бөгөөд 2 дугаар улирлын тайланг хуулийн хугацаанд хүргүүлэхээр ажиллаж байна.

Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдалд өдөр тутам хяналт тавьж, анхан шатны болон Нягтлан бодох бүртгэл хөтлөн, 2025 оны хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж БЗД-ийн Нийгмийн даатгалын газрын даргын “Өмч хөрөнгө, эд аж ахуйн тооллого хийх тухай” тушаалын дагуу 6-р сарын 5-7-ны өдөр үнэн зөв, чанартай хийж тооллогын үр дүнг холбогдох байгууллагад тайлагнаж ажилласан. хагас жилийн хөрөнгийн тооллогыг чанартай, үр дүнтэй хийхэд анхаарч тооллогын материалыг НДЕГ-ын СБХОГазарт тогтоосон хугацаанд хүргүүлсэн. Байгууллагын бүх үндсэн болон үндсэн бус хөрөнгийн ашиглалт, эзэмшилт, хадгалалтыг сайжруулах зорилгоор өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдэд ажлыг хуваарилан бүх хөрөнгийг биечлэн үзэж танилцаж тоолж бүртгэлийг сайжруулах тал дээр анхааран ажилласан. 2025 оны 4-р сарын 03-ны өдрийн “Үндсэн хөрөнгө шилжүүлэх, актлах, ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэх жагсаалт” ирүүлэх тухай 01/767 тоот албан бичгээр байгууллагын хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын хугацаа сунгах, цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийг актлах 16 хуудас бүхий саналыг хүргүүлсэн. Байгууллагын газрын 000437367 дугаартай гэрчилгээний хугацаа 2019 онд дууссан тул Ланд Овнер ХХК-тай гэрээ байгуулан 382м2 талбайд Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийлгэн дүгнэлтийг гаргуулан Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд холбогдох материалуудыг бүрдүүлэн өгч “иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээ” №01110-2025/00310-аар гэрчилгээний хугацааг шинэчилж №0000348931 дугаар бүхий шинэ гэрчилгээг авсан. ТӨБЗГ-ын даргын 2024 оны 3-р сарын 21-ний өдрийн 139 дүгээр тогтоолын дагуу БЗД-ийн 23-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Алтан орлогын гол” ХХК-ийн эзэмшлийн “Эрхэт” худалдааны төвийн байранд 30,29 м.кв талбайг түрээслэх зөвшөөрөл хүссэн



01/56 тоот албан бичгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2025 оны 02-р сарын 24-ний өдөр хүргүүлж Зөвшөөрсөн хариуг хүлээн авсан.



Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны 64 дүгээр тэмдэглэлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын




газрын 2025 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө, тус газрын даргын баталсан удирдамжийн дагуу Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын газрын төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалт, газар эзэмшил, ашиглалт, баталгаажуулалтын үйл ажиллагаанд Төрийн өмчийн хяналт

шалгалтын хэлтсийн дарга, санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч Ц.Түвшинзаяа, мэргэжилтэн, санхүүгийн хяналт шалгалтын Улсын байцаагч Ч.Батчимэг, мэргэжилтэн Я.Эрдэнэбаатар нар баримт /систем/-ын шалгалт хийсэн. Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын газарт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хийсэн хяналт шалгалтаар төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалттай холбоотой зөрчил дутагдал илрээгүй болно.



Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж НББ-ийн тухай хууль болон дүрэм журмын дагуу бүртгэлийг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд 2024 оны үйл ажиллагаа, сангийн санхүүгийн тайланд Аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлт авч ажилласан. Мөн өмнөх аудитын дүгнэлтээр ирүүлсэн албан шаардлагын биелэлтийг хангахаар ажил зохион байгуулан ажиллаж байна. 2024 оны сангийн тайланд түүврийн аргаар аудит хийсэн бөгөөд асуудлын бүртгэлээр алдаа зөрчил илрээгүй болно.



2025.02.13-ны өдрийн 01/332 тоот тушаалаар НДЕГ-ын даргын арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г ирүүлсэн бөгөөд манай дүүрэг гэрээг мөрдөн Хаан банк, Голомт банк, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банк, Капитрон банк зэрэг арилжааны 5 банктай хамтран ажиллаж өдөр тутмын орлого зарлагын гүйлгээг харилцагч банкаар дамжуулан хэвийн явуулж байна.

Өмнөх оны гэрээний биелэлтийг банкны захирал төлөөлөгч нартай нэг бүрчлэн уулзаж гэрээний заалт бүрээр оноогоор дүгнэх зарчмаар дүгнэн НДЕГ-т хүргүүлэн ажилласан.

Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй ажилласан.

Сангийн орлого, зарлагын гүйлгээ бүрийг өдөр өдрөөр банкны хуулгатай тулган мэдээллийн санд бүртгэж тайлан мэдээ гаргахад бэлтгэн ажиллаж байна.

Тэтгэвэр, тэтгэмж тогтоолгохоор хүсэлт гаргасан иргэдийн мэдээллийг улсын бүртгэлийн мэдээллийн сан болон нийгмийн даатгалын цахим мэдээллийн сантай тулган ажиллаж байгаа бөгөөд шимтгэл төлөгч даатгуулагчийн нэр улсын бүртгэлийн мэдээллийн нэртэй нийцсэн байна



Өмнөх онуудад шимтгэл төлж байсан даатгуулагчдын овог, нэр, регистрийн дугаар улсын бүртгэлийн мэдээллийн сантай 99,7 % нийцсэн байна гэж төлөвлөсөн бөгөөд эхний хагас жилийн байдлаар зөрсөн мэдээлэл байхгүй байна.

НДЕГ болон Ай ти зон ХХК-иас зохион байгуулсан программтай холбоотой цаг үеийн сургалтуудад бүрэн хамрагдаж төвлөрсөн орлого бүртгэх таниулах, өглөг бүртгэх өглөг хаах зэрэг үйлдлийг бүрэн хийж байна. Мөн алдаатай буюу харилцагч таниагүй хуулгыг бүрэн таниулж хагас жилийн санхүүгийн тайланг гаргах бэлтгэл ажлыг хийж байна.

Шинэ программтай холбоотой шинэчлэлийн саналыг Жи́ра болон МТТөвд бичгээр хүргүүлэн ажилласан. Нийгмийн даатгалын ерөнхий газрын хэмжээнд программын шинэчлэл хэрэгжилтийн талаар цугларалт уулзалт зөвлөгөөн хийсэн бөгөөд үүнд манай хэлтсээс сангийн нягтлан бодогч оролцож хөгжүүлэлтийн санаа болон алдаа өгч байгаа зүйлсийг жагсаан холбогдох мэргэжилтнүүдэд хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын газрын Санхүү бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу ААНБ тус бүрийн үлдэгдлийг тооцоо нийлэн үлдэгдлийг баталгаажуулан ажилласан. Тус газраас авсан судалгааг тухай бүр хийж явуулсан.

Батлагдсан төсөв хүрэхгүйгээс болж НДШ, ХХОАТатварын өглөг үүсэж байгаа тухай бүр буюу 4 удаа албан бичгийг холбогдох баримтын хамт НДЕГ-т хүргүүлсэн байгаа болно.

***Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, Өр авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах ажлын талаар:***

Малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч иргэдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах үйл ажиллагааг тухай



бүрт зохион байгуулж Нийгмийн даатгалын багц хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан ажил олгогч, иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг Баянзүрх дүүргийн 1, 5, 18, 30, 33, 41, 43 дугаар хороод давхардсан тоогоор нийт 1200 гаруй иргэд зөвлөгөө мэдээлэл хүргэх, Төрийн өмчит болон төрийн өмчийн



оролцоотой хуулийн этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа анги, зэвсэгт хүний анги нэгтгэл зэрэг 12 байгууллагын 910 даатгуулагч, хувийн хэвшлийн нийт 25 ААНБ-ын 520 даатгуулагч нийт 1430 даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулан хамтран ажиллалаа. Офицер зах,



Амгалан зах, Тэнгэр худалдааны төв, Дүнжингарав худалдааны төв, Сандей, Нарантуул ОУХТөвүүдээр явж нийт 429 хүнд сайн дурын даатгалын талаар зөвлөгөө мэдээлэл хүргэн 7-н иргэнтэй хамтран сайн дурын даатгал төлөхийг уриалсан бичлэг хийсэн.

Мөн 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр газрын пэйж хуудсаар дамжуулан “Сайн дурын даатгал” сэдвээр лайв хүргэн танилцуулан ажиллаа

2025 оны эхний хагас жилд сайн дурын даатгалд 1888 даатгуулагч хамруулсан. Үүнээс 0-3 насны хүүхдээ асарч буй ээж 139, малчин 20, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асар буй эцэг эх 101-г хамруулж Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг сайн дурын даатгалд шинээр хамруулан ажиллаж байна.





2025 оны эхний хагас жилд шинээр 228 ажил олгогч, албан журмын даатгуулагч 5324 хамруулж Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг 100 хувь биелүүлсэн байна.

Хуримтлагдсан авлага барагдуулах 120 хоногийн аянг зарлан, байгууллагын өр, авлагын хэмжээ насжилтыг тодорхойлсон судалгааг гарган, тайлан шимтгэлийн авлага барагдуулах журмын дагуу арга хэмжээг шат дараалан авч, гадуур ажиллах хуваарь гарган өртэй ажил олгогчтой уулзалт хийн ажиллаж байна.

11029,64 сая төгрөгийн өртэй 188 ажил олгогчид улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, 47345,07 сая төгрөгийн өртэй 2112 ажил олгогчийн арилжааны банкин дах харилцах дансны зарлагын гүйлгээг хааж, 11886,32 сая төгрөгийн өртэй 107 ажил олгогчтой авлага барагдуулах гэрээг байгуулан ажилласан.

Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг төлүүлэхээр нийт 67 аж ахуйн нэгж байгууллагын 5,765.6 сая төгрөгийн шимтгэл, 433.9 сая төгрөгийн алданги нийт 6,199.5 сая төгрөгийг нэхэмжлэн шүүхэд шилжүүлсэн. Үүнээс 8 аж ахуйн нэгж байгууллагын 4,660.8 сая төгрөгийн шимтгэл, 4.8 сая төгрөгийн алданги нийт 4665,7 сая төгрөгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад албадан гүйцэтгүүлэхээр өгсөн. 10 аж ахуйн нэгж байгууллагын хаяг байршил, эзэн холбогдогч олдохгүйн улмаас шүүхээс хэрэгсэхгүй болгосон бөгөөд шүүхээр эрэн сурвалжлуулахаар дахин материал бүрдүүлэн өгсөн. Шинээр нэмж өр үүсгэхгүй байх тал дээр анхаарч аж ахуйн нэгж байгууллагуудтай уулзалт, гэрээ байгуулан ажиллаж байна.

Оны эхний авлага 77422,6 сая төгрөг байснаас 2748 ажил олгогчийн 20240,71 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдуулж, 718 ажил олгогчийн 6258,13 сая төгрөгийн авлагыг хэсэгчлэн барагдуулж, 3466 ажил олгогчийн 26498,85 сая төгрөгийн авлагыг барагдуулж оны эхний авлагыг 34,2 хувиар бууруулан ажиллаж байна.

2025 оны эхний хагас жилд шинээр 2964 ажил олгогчийн 50924,82 сая төгрөгийн авлага үүсээд байгааг ангилан судалж журамд заасны дагуу шат дараалалсан арга хэмжээг авч барагдуулан нэмж өр үүсгэхгүй байхаар анхааран ажиллаж байна.



Баянзүрх дүүргийн тамгийн газартай хамтран 200 гаруй төсөвт байгууллагуудын нягтлангуудад хууль тогтоомж, журмын талаар зөвлөгөө мэдээлэл хүргэж ажилласан.

2024 оны эцэст төсөвт болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өр 444,34 сая төгрөг байсаныг эхний хагас жилд бүрэн барагдуулж өргүй гарсан. Цаашид өр үүсгэхгүй байхаар сургалт орж анхааран ажиллаж байна. Сангийн орлогын төлөвлөгөөг сар болон улирлаар жигд ханган биелүүлж эхний хагас жилийн байдлаар 245192,35 сая төгрөгийн орлого хуримтлуулахаас 245265,90 сая төгрөг буюу 100,03 хувиар биелүүлэн ажиллаж байна.

Ажил олгогчийн нягтлан бодогчдод “Нийгмийн даатгалын багц хууль”-ийн шинэчилсэн найруулга, хууль тогтоомжид орсон өөрчлөлтүүд, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд анхаарах асуудлууд, нэмэгдсэн болон нэршил өөрчлөгдсөн датгуулагчийн төрлийн кодын талаархи мэдээллийг өгөн ажилласан. Мөн олон нийтийн цахим хэрэгсэл болон баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст тайлан өгдөг аж ахуйн нэгж байгууллагын цахим группт мэдээллийг өгөн ажиллаж байна. Хэлтсийн давхар тус бүрт байрлах мэдээллийн самбарт хуулийн өөрчлөлттэй холбоотой шинэ гарсан зөвлөгөө мэдээллийг тухай бүрт нь шинэчлэн оруулж сурталчлан ажиллаж байна.



### **Тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хугацаанд нь олгох талаар**

Тэтгэврийн тогтоолт, олголтын талаар

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд өдөр тутам шинээр тогтоогдсон тэтгэвэр, ажилласан жил нэмүүлсэн болон цалин өөрчилсөн тэтгэвэр, тахир дутуугийн тэтгэврийн хөдөлмөрийн чадвар алдсан хувь, хугацааны өөрчлөлт, тэжээгчээ алдсаны тэтгэврийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн өөрчлөлт зэрэг тэтгэвэрт гарч буй өөрчлөлтүүдийг тухай бүр холбогдох баримт материалыг тэтгэврийн мэдээллийн баазад тулган шалгаж, баталгаажуулан ажиллаж байна.

Тайлант хугацаанд шинээр тогтоосон 1039 өндөр насны тэтгэвэр, 328 хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, 85 тэжээгчээ алдсаны тэтгэвэр, цэргийн алба хаагчийн тэтгэвэр 39 нийт шинээр тогтоогдсон 1491 тэтгэвэр, ажилласан жил нэмүүлсэн 820, хөдөлмөрийн чадварын хувь, хугацаа өөрчлөгдсөн 1104, шилжиж ирсэн 111, шилжиж явсан 154, нас барсан 504 тэтгэвэр авагчийн мэдээллийг бүртгэж оруулсан байна.

Тайлант хугацаанд шинээр тогтоогдсон тэтгэвэр, олголтын зардал төрөл тус бүрээр:

2025 оны 06 дугаар сарын 05-ний өдрийн байдлаар өндөр насны тэтгэвэр авагч 43735 даатгуулагчид 182.179 тэрбум төгрөг олгосноос 1039 нь иргэн шинээр тогтоолгосон байна. Тахир дутуугийн тэтгэвэр авагч 5816 даатгуулагчид 18.082 тэрбум төгрөгийн тахир дутуугийн тэтгэвэр олгосноос 328 иргэнд шинээр тогтоож олгосон. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 2070 даатгуулагчид 6.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосноос 85 иргэнд шинээр тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгосон.

Тэтгэвэр тогтоолгосноос хойш нийгмийн даатгалын хуулийн дагуу 120 иргэний ажилласан жилийн нэмэгдлийн хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэсэн. Мөн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээнд өөрчлөлт хийх 56, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалсан 182, тэжээгчээ алдсаны тэтгэврийн өөрчлөлт /хүүхдийн тоо өөрчлөгдөх/ 18-ийг тус тус цахимаар хийсэн.

Сар бүрийн тэтгэврийн файл явахаас өмнө буюу сарын дундуур баталгаажсан шинэ тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа сунгагдсан тэтгэвэр авагчдын тэтгэврийн мөнгийг 7 хоног бүр банкинд жагсаалтаар бэлтгэн хүргүүлдэг бөгөөд жилийн эцсийн байдлаар 18 удаагийн 10523 тэтгэвэр авагчийн мэдээллийн баазын сунгалт болон олголтыг хянаж, банкинд бэлдсэн файлыг нэгтгэн сангийн нягтлан бодогчид хүлээлгэн өгч ажиллаж байна.

Сар бүр давхар регистрийн дугаартай сар (1600 гаруй) нийт давхардсан тоогоор 48447 тэтгэвэр авагчийн мэдээлэл болон олголтыг тэтгэврийн мэдээллийн баазтай мөн улсын хэмжээнд ND LAV-программтай тулган шалгасан.

Тайлант хугацаанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд 2 дугаар улиралд 99 тэтгэвэр авагчийн 286,48 сая төгрөгийн авлагыг барагдуулсан.

НДЕГ болон ННДГ-ын хамтарсан шалгалтаар тэтгэвэр илүү олгосон зөрчилтэй 65 тэтгэвэр авагчийн 54,5 сая төгрөг илүү олгогдсоноос 24 сая төгрөгийн зөрчлийг барагдуулж 15 тэтгэвэр авагчийн 26,6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тэтгэмж тогтоолт, олголтын талаар



Хөдөлмөрийн чадвар түр алдалт, жирэмсэн болон амаржсан, оршуулга, үйлдвэрлэлийн ослын хөдөлмөрийн чадвар түр алдалт, ажилгүйдлийн тэтгэмжүүдийн анхан шатны материал баримтыг нягтлан шалгаж, хүлээн авч, тухай бүр шалгаж программд оруулж ажилласан. Мөн хөдөлмөрийн чадвараа түр алдсаны болон жирэмсэн, амаржсаны тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмж авахаар хүсэлт гаргасан даатгуулагч иргэдийн мэдээллийг тухай бүр нь нийгмийн даатгалын нэгдсэн сангийн цахим мэдээллийн сантай тулган ажиллаж байна.

Тайлант хугацаанд тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэмж 2701 даатгуулагчид, жирэмсэн болон амаржсаны тэтгэмж 1452 даатгуулагчид, оршуулгын тэтгэмж 351 даатгуулагчид, нийт 4504 даатгуулагчийн тэтгэмжийг бодож олгосон байна.

Мөн ажилгүйдлийн даатгалын сангаас нийт 1151 даатгуулагчийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас нийт 30 даатгуулагчийн тэтгэмжийг бодож олгуулсан.

### **НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН ТАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:**

Монгол улсын Засгийн Газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 450 тоот тогтоолоор баталсан журмын хавсралтад заасан тэтгэвэр шинээр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичиг, тэтгэвэр олгох журам, 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 438 дугаар тогтоолоор баталсан даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгох журам, түүний хавсралтанд заасан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, заасны дагуу хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон , амаржсаны, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох болон ажилгүйдлийн тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, даатгуулагчид тэтгэмж олгох харилцааг зохицуулсан журмын хавсралтанд заасны дагуу мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01/47 тоот Нийгмийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх зөвлөмжийн дагуу сайн дурын даатгуулагчийн сайн дурын даатгуулагчийн мэдээллийг программд овог , нэр , регистр, болон хаягийн мэдээлэл, холбоо барих утас зэрэг мэдээллийг үнэн зөв бүртгэн, мэдээллийг үнэн зөв оруулж, гэрээг шинээр байгуулах болон сунгалтыг хийж, тэтгэвэр , тэтгэмж тогтоолгох иргэдийн материалыг шалган, анхан шатны баримтыг бүрдүүлэн, хүлээн авч, бүртгэл хөтлөн, мэдээллийг Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн сан буюу Sicoc програмд үнэн зөв оруулан, мэдээллийн баазыг бүрдүүлж, тэтгэвэр, тэтгэмж тогтоолтын байцаагчид хүлээлгэн өгч, ажиллаж байна.

Үйлчилгээ үзүүлсэн иргэдээ цахим [ndaatgal.bzd.gov.mn](http://ndaatgal.bzd.gov.mn) Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс цахим бүртгэлд оруулан бүртгэж хэвшсэн бөгөөд эхний хагас жилд үйлчилгээ үзүүлсэн 30996 даатгуулагчийн мэдээлэл утасны дуаарыг , үзүүлсэн үйлчилгээтэйгээ тухай бүрт нь бүртгэн оруулсан байна. Уг бүртгэлээр нэг иргэн 2-3 үйлчилгээ авсанг 1 үйлчилгээн дээр бүртгэл хөтөлж, үйлчилгээ үзүүлсэн иргэнийг тоог давхардалгүй оруулж байна.

2025 оны эхний хагас жилд нэг цэгийн үйлчилгээ, цахим мэдээллийн тасаг болон нийслэлийн Дүнжингарав үйлчилгээний төв дэх салбар нийлээд нийт 6622 даатгуулагчийн сайн дурын даатгалын гэрээг, сунгах болон шинээр байгуулснаас 0-3 насны хүүхэдтэй ээж /сангаас/-131, 0-3 насны хүүхэдтэй ээж /улсын төсвөөс/-101, 0-18 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг/эх/-164, малчин-9 , нийт 1128 сайн дурын даатгуулагч шинээр хамруулсан байна.

Нийт шинэ тэтгэврийн 1766 материал хүлээн авснаас өндөр насны тэтгэвэр-1278 , хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр-383, тэжээгчээ алдсаны тэтгэвэр-105 иргэний тэтгэвэр тогтоолгох өргөдөл, анхан шатны материалыг шалгаж бүрдүүлэн авч , тэтгэвэр тогтоолтын байцаагчид хүлээлгэн өгч ажиллалаа. Иргэдэд үзүүлсэн үйлчилгээг багцлан авч үзвэл :

**1 цэгийн зөвлөгөө, цахим мэдээллийн тасгийн 2025 оны эхний хагас жилийн  
үйлчилгээний нэгтгэл**



| №  | Даатгуулагчдад үзүүлсэн үйлчилгээ                    | Үйлчилгээ үзүүлсэн тоо |
|----|------------------------------------------------------|------------------------|
| 1  | Ажилгүйдлийн тэтгэмжийн зөвлөгөө өгөх                | 1346                   |
| 2  | Ажилгүйдлийн тэтгэмжийн материал хүлээн авах         | 2531                   |
| 3  | Даатгуулагчийн НДШ төлөлтийн тодорхойлолт            | 478                    |
| 4  | НДС-с тэтгэврийн эрх үүсээгүй тодорхойлолт           | 294                    |
| 5  | НДШ тайлан хүлээн авах, баталгаажуулах               | 8                      |
| 6  | Нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмж      | 320                    |
| 7  | СДД -н гэрээ байгуулах, сунгах                       | 6622                   |
| 8  | СДД -н зөвлөгөө өгөх                                 | 2764                   |
| 9  | Тэтгэврийн банк өөрчлөх                              | 281                    |
| 10 | Тэтгэвэр дээр ажилласан жил нэмэх                    | 1077                   |
| 11 | Тэтгэврийн зөвлөгөө өгөх                             | 7353                   |
| 12 | Тэтгэврийн материал хүлээж авах                      | 1727                   |
| 13 | Тэтгэврийн сунгалт хийх                              | 20                     |
| 14 | Тэтгэврийн тусгай зохицуулалт                        | 72                     |
| 15 | Тэтгэврийн хувийн хэргээс материал хуулбарлаж өгөх   | 52                     |
| 16 | Тэтгэврийн шилжилт хөдөлгөөн хийх                    | 105                    |
| 17 | Тэтгэвэр авч байгаа тодорхойлолт                     | 379                    |
| 18 | Тэтгэвэр тогтоолгосон цалин өөрчлөх өргөдөл /хүсэлт/ | 7                      |
| 19 | Тэтгэмжийн зөвлөгөө өгөх                             | 889                    |
| 20 | Тэтгэмжийн материал хүлээн авах                      | 876                    |
| 21 | Шүүхийн зөвлөмжийн хуудас                            | 31                     |
| 22 | ЭМД -н үйлчилгээ                                     | 14                     |
|    | <b>Нийт</b>                                          | <b>27158</b>           |

**Дүнжингарав нэг цэгийн үйлчилгээний төвийн 2025 оны эхний хагас жилийн  
үйлчилгээний нэгтгэл**

| Д.д | Иргэдэд үзүүлсэн үйлчилгээ            | Үйлчилгээ үзүүлсэн тоо |
|-----|---------------------------------------|------------------------|
| 1   | Ажилгүйдлийн тэтгэмжийн зөвлөгөө өгөх | 51                     |

|             |                                                 |             |
|-------------|-------------------------------------------------|-------------|
| 2           | Ажилгүйдлийн тэтгэмжийн материал хүлээн авах    | 5           |
| 3           | АО-н НДШ төлөлтийн тодорхойлолт                 | 3           |
| 4           | Бусад                                           | 30          |
| 5           | Даатгуулагчийн НДШ төлөлтийн тодорхойлолт       | 912         |
| 6           | НДС-с тэтгэврийн эрх үүсээгүй тодорхойлолт      | 4           |
| 7           | НДШ төлөлтийн талаарх тодорхойлолт /өртэй эсэх/ | 8           |
| 8           | Оршуулгын тэтгэмж                               | 31          |
| 9           | Өргөдөл хүлээн авах                             | 22          |
| 10          | СДД -н гэрээ байгуулах, сунгах                  | 732         |
| 11          | СДД -н зөвлөгөө өгөх                            | 873         |
| 12          | Тэтгэврийн банк өөрчлөх                         | 2           |
| 13          | Тэтгэврийн жил нэмэх                            | 56          |
| 14          | Тэтгэврийн зөвлөгөө өгөх                        | 610         |
| 15          | Тэтгэврийн материал хүлээж авах                 | 39          |
| 16          | Тэтгэврийн сунгалт хийх                         | 1           |
| 17          | Тэтгэврийн тусгай зохицуулалт                   | 4           |
| 18          | Тэтгэврийн шилжилт хөдөлгөөн хийх               | 6           |
| 19          | Тэтгэвэр авч байгаа тодорхойлолт                | 32          |
| 20          | Тэтгэмжийн зөвлөгөө өгөх                        | 204         |
| 21          | Тэтгэмжийн материал хүлээн авах                 | 26          |
| 22          | Шүүхийн зөвлөмжийн хуудас                       | 15          |
| 23          | ЭМД -н үйлчилгээ                                | 126         |
| <b>Нийт</b> |                                                 | <b>3838</b> |

Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч иргэдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах, иргэдэд төрийн үйлчилгээг ойр болгох үүднээс газрын даргын гаргасан төлөвлөгөөнд тусгагдсан хуваарийн дагуу зах, худалдааны төв, хороодоор ажиллалаа. Уг ажлын хүрээнд Нарантуул, Баялаг-Ундраа, Дүнжингарав, Тэнгэр плаза худалдааны төв, Офицер зах, Амгалан зах, болон хороодоор ажиллаж, -398 иргэнд сайн дурын даатгалын зөвлөгөө, - 50 Иргэнд нийгмийн даатгалын аппликэйшний имэйл хаяг, бүртгэлтэй утасны дугаар солих үйлчилгээ, --283 Иргэнд тэтгэврийн зөвлөгөө, -133 иргэнд тэтгэмжийн зөвлөгөө өгч, мөн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 03 тоот тогтоолоор Улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэг цагт 4715 төгрөг буюу сард 792000 төгрөг байхаар тогтоосонг танилцуулан ажиллалаа.



2025.05.15-ны өдөр Сүхбаатарын талбайд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан “Ажилтай өрх-аз жаргалтай гэр бүл” нээлттэй өдөрлөгт тус тасгийн байцаагч Бямбажаргал оролцон зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Энэ ажлын хүрээнд нийт 35 даатгуулагчид тэтгэвэр тогтоохтой холбоотой зөвлөгөө, мэдээлэл өгч, 3 хүнд шинээр ажил олгогч шимтгэл төлөгчөөр бүртгүүлэх зөвлөгөө, 15 хүнд сайн дурын даатгалын зөвлөгөө өгч ажиллалаа. 2025.05.19-нд 18 хороонд 2025.04.09-нд 43 хороонд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулахад байцаагч Нямсүрэн, Элбэгзаяа нар ажиллан 28 даатгуулагчид тэтгэврийн зөвлөгөө, 0-3 ээжийн гэрээ 1, энгийн сайн дурын гэрээ 3 –г хийсэн. Мөн 2 рийл хийж газрын цахим хуудсанд оруулан түгээж ажилласан. Мөн өндөр насны тэтгэвэр тогтоолгосон зураач Л.Өнөрчимэг Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын газрын байцаагч нарын харьцаа хандлага, нэг цэгийн үйлчилгээний тасгийн орчин нөхцлийн талаар лайв мэдээлэл хийсэн нь 16,1 мянган үзэгчийн хандалттай байсан.



✓ Энэ үеэр харилцан ярилцаж, зөвлөгөө мэдээллийг өгч, шийдвэрлэх арга замыг тодорхойлсон үр дүн бүхий сургалт боллоо.



Цаасаар-585 буюу 92,7% Цахим Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах ERP 11-11 төвөөр -46 буюу 7,3%

Үүнийг төрлөөр нь ангилбал:

Хүсэлт –587 буюу 93%

Гомдол – 41 буюу 6,5%

Талархал – 3 буюу 0,5% ирсэн байна.

Үүнийг агуулгаар нь ангилбал:

Тэтгэврийн асуудлаар – 19 буюу 3%

Тэтгэмжийн асуудлаар – 45 буюу 7,13%

Сайн дурын даатгалын асуудлаар – 229 буюу 36,3%

Регистр, овог нэр нэгтгэх – 99 буюу 15,68%

Нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэх асуудлаар – 72 буюу 11,4%

Нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлт буцаах – 150 буюу 23,7%

Гүйлгээ залруулах тухай – 17 буюу 2,7%

Шийдвэрлэлтийн дундаж хугацаа – 6 хоног

Шийдвэрлэсэн байдал – 631. Ажлын 3-14 хоногийн дотор шийдвэрлэн, хариуг хүргүүлэн ажиллаж байна. 100 хувь шийдвэрлэн ажиллаж байна.

**Нийгмийн даатгалын байгууллагын салбарын хэмжээнд архивын үйлчилгээг сайжруулах, ажил олгогч, иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үзүүлэх чиглэлээр:**

Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах, нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагч, иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүргэх, үйлчилгээний чанар хүртээмж, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, Дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулан, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/222 дугаар тушаалын хавсралт “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын дагуу үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна

- Хэргийн индекс болон БНШКомиссын гишүүдээ шинэчлэн 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж газрын даргаар батлуулсан.
- Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтаа газрын албан хаагч нараас санал авч 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлуулсан.
- Өмнөх онд үүссэн баримтаа архивд хүлээж авах хуваарь болон, архивт баримт хүлээлгэж өгөх журмаа 2025 оны 01 дүгээр сарын 10 өдөр батлуулсан.
- Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт албан хаагч нарт орж архивд нөхөн бүрдүүлэлт хийх гарын авлага боловсруулан газрын дарга болон хэлтсийн дарга нараар хянуулан гарын үсэг зуран баталгаажуулж хэлтсийн дарга нарт хүлээлгэн өгсөн.
- Газрын байцаагч нарын үйл ажиллагааны явцад үүсэж хөтлөгдсөн урьд оны баримтуудыг “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ын дагуу, “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын 3.5 дахь заалтыг үндэслэн Газрын даргын баталсан хуваарийн дагуу эхний улиралдаа хүлээн авсан.Байнга хадгалах 121 баримт, 70 жил хадгалах 885 баримт, түр хадгалах 311 баримт, өндөр нас 430, тэжээгчээ



- алдсан 16, хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр 380, ажилгүйдлийн хувийн хэрэг 108 боть тус тус хүлээн авч нөхөн бүрдүүлэлт хийсэн.
- Үндэсний архивын газрын даргын 2007 оны 160 дугаар тушаалаар батлагдсан Байгууллагын үйл ажиллагаанд үүссэн удирдлагын нийтлэг баримт бичгийн хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт, түр хадгалах баримтын хадгалах хугацаа дууссан баримтыг ҮЖ-ын заалтаар ач холбогдолгүй хадгалах хугацаа нь дууссан 2006-2013 оны нийт 387 цаасан суурьтай баримт, 2013-2024 оны хоёр хэргийн 66 баримтыг устгах нэрийн жагсаалт гаргаж газрынхаа БНШК-ын хурлаар оруулан БЗДЗДТГ-ын архивын хэлтсээр хянуулан Тамгын газрын архивын дэргэдэх БНШАЗК-ын хурлаар 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр батлуулсан.
  - БЗДЗДТГ-ын архивын тасагт нөхөн бүрдүүлэлтийн хуваарийн дагуу 2010-2017 оны нийт 71 байнгын баримтыг ялган бүртгэл үйлдэн хүлээлгэн өгсөн. Мөн байгууллага дээр хадгалах байнгын 1997-2017 оны баримт, 70 жилийн 2003-2017 оны баримт, түрийн 2013-2017 оны баримтын бүртгэлүүдээ Тамгын газрын архивын дэргэдэх БНШАЗК-ын хурлаар 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр батлуулсан.
  - Санхүүгийн 70 жилийн баримт, түрийн баримт нь нэг байсныг салгаж 70 жил, түрийн баримтын бүртгэл үүсгэн цэгцэлсэн.
  - 2009-2023 он хүртэл ӨН, ТД, ТА хувийн хэргийг нь эхнээс хайрцаг руу нь шахаж архивын дардас дарж хадгаламжийн нэгж үүсгэн бүртгэлжүүлсэн. Мөн бүртгэлгүй ТД 15 хайрцаг хувийн хэрэг буюу 310 хүний хувийн хэрэг шивж бүртгэл үйлдсэн.
  - 1997-2024 оны Байнга хадгалах 418 боть баримтыг 01-418 хүртэл нэг бүрчлэн дугаарлан хайрцагласан.
  - Байгууллага дээрх 70 жил хадгалах 01-535 боть баримтыг дугаарлан хайрцаглаж, хадгалах нөхцөлийн сайжруулсан.
  - Устгах баримт ялгасантай холбогдуулан 2013-2023 оны баримтын зай шахаж нийт 2545 баримтыг тавиурт өрсөн.
  - Нийгмийн даатгалын шимтгэлийн 1995-2024 оны тайланг бүртгэл үйлдэж үдэж хавтаслан, дугаарлан цэгцэлсэн. Мөн 70 жилийн баримт, байнгын баримт, түрийн баримтаа бүртгэлжүүлэн газрын даргаар тамга даруулж, гарын үсэг зурж баталгаажуулан хавтаслаж хайрцагласан.
  - Дотооддоо байцаагч нартай санхүүгийн баримт, хяналт шалгалтын баримт, өндөр нас, тэжээгчээ алдсан, тахир дутуу, ажилгүйдлийн хувийн хэргээс давхардсан тоогоор 525 хадгаламжийн нэгж түр ашиглуулан бүртгэл үйлдсэн.
  - 2019-2023 оны тахир дутуугийн хувийн хэргээс нийт 20 даатгуулагчид өөрт хэрэгтэй нийгмийн даатгалын дэвтэр, акт зэрэг материалыг хувийн хэрэг дээр нь бүртгэл үүсгэж гарын үсэг зурж хүлээлгэн өгсөн.
  - Хуулийн зөвлөхөөр уламжлуулан архивыг хамгаалах төлөвлөгөө боловсруулан батлуулж, түүнд гал түймэртэй тэмцэх бүлэг байгуулах, ажлын зохион байгуулалт, бүлгийн гишүүдийн үүргийг тусгаж хэрэгжүүлэн, ажлын байрны галын аюулгүй байдлыг шалгуулж, дүгнэлт гаргуулсан.
  - НДЕГ, БЗДЗДТГ-ын Архивын тасагт баримтын тоо мэдээ 1,1 удаа, дээд газраас архивд ирсэн ҮЖ санал асуулгад 2 удаа саналаа цаг хугацаанд албан бичгээр хариу хүргүүлэн ажилласан байна.

- Архивын баримтад тооллого явуулах, зохион байгуулах ажлын хэсгийг батлуулахаар тушаалын төслөө боловсруулсан байна.
- Хос бичгээр архивынхаа нягтруулсан шүүгээний хаягжилт болон баримтын



хайрцагны хаягжилтыг шинчлэн хийх ажил 20% явж байна.

- Архивын өрөөнийхөө температур, чийг хэмжилтийн бүртгэлийг цаг хугацаанд нь хөтлөн ажиллаж байгаа.
- Лавлагааны анхан шатны бүртгэлийг өдөр тутамдаа бүртгэж хэвшсэн.
- ХЧАТ, ӨН, ТА-ын зогсоогдсон хувийн хэргийг бүртгэлийн дагуу хадгаламжийн нэгж үүсгэн хувийн хэргийн байцаагч нараасаа тухай бүр нь хүлээн авч архивлаж байна.
- Эрүүл ахуй, ариутгал, халдваргүйжилтийн дэглэмийг баримталж 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр “Орхон-Овоот”-ХХК гэрээ хийн хамтран ажиллаж байна.

### Иргэд, даатгуулагчид олгосон лавлагаа



Эхний хагас жилийн байдлаар аймаг, дүүргүүдээс ирсэн иргэд даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа авах хүсэлтийг хүлээн авч ажлын 3 хоногт багтаан гаргаж [intranet.gov.mn](http://intranet.gov.mn) болон дотоод сүлжээ инбитээр холбогдох хөнгөн шуурхай үйлчилж байна.

Дотооддоо шимтгэл төлөлтийн 1991-1994 оны лавлагаа болон нөхөн даатгалын лавлагааг 10-15 минутад, 1995-2024 оны лавлагааг ажлын 1-3 хоногт багтаан цаасан суурьтай баримтаа үндэслэн шүүж гаргаж байна.

Шаардлагатай тохиолдолд 2000-2024 онуудад ажилласан хугацааны лавлагааг [local.ndaatgal.mn](http://local.ndaatgal.mn)-ээс QR кодоор шимтгэл төлсөн дүүрэг харгалзалгүй тухай бүр лавлагаа олгон ажиллаа. Мөн 1995-2005 оны нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан цахимжуулсантай холбоотойгоор SICOS цахим программыг ашиглаж өөрийн болоод нийслэлийн бусад аймаг, дүүргүүдийн тайлан харж иргэд даатгуулагчид хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

- 2000-2024 оны шимтгэл төлөлтийн QR лавлагааг 683 даатгуулагчид гаргаж олгосон.
- Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн өөрчлөлтүүдийг сурталчлан таниулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг давхардсан тоогоор 125 иргэнд хүргэж ажилласан.

## Лавлагаа олгосон тоон үзүүлэлт



### Эрүүл мэндийн магадлалын чиглэлээр

Тус зөвлөл нь тайлант хугацаанд Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож, сунгах, цуцлах 44 удаагийн хурал хийгдэж. Шинээр тогтоосон- 407, сунгалт-8248, цуцлалт-298 шийдвэрлэж, иргэдийн оношны баталгаажилтад хяналт хийлээ.

Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт, шалгалтыг 2 зохион байгуулж, үр дүнг тооцсон байна. Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ижил мэргэжилтний үзлэгийг 2 удаа зохион байгуулж эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадвар сайжирч иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэсэн. Төлөвлөгөөний дагуу Диспансерын хяналтын сайжруулах эрүүл магадлалын зөвлөлд илгээх, эмнэлгийн бичиг баримтын бүрдүүлэлтэд байнгын хяналт хийж, гарсан зөрчлийн 100 хувь арилгуулан ажиллаж байна.

Орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд суурь болон харьцуулсан судалгааг 2 удаа хийж дүгнэн тайланг 2 удаа хүргүүлэн ажиллаж байна. Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс цахимаар зохион байгуулсан 4 удаагийн сургалтад 36 эмч, мэргэжилтнийг хамруулсан. Авлигатай тэмцэх газраас зохион



байгуулсан авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2 удаагийн сургалтад зөвлөлийн нийт гишүүдийг хамруулж ажилласан байна.

### **Маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөлийн ажлын талаар**

Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын газрын дэргэдэх Маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөл байгуулах тухай газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/18 дугаар тушаалаар салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. Захиргаа, хяналтын хэлтсийн дарга Т.Бат-Амгалан, Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтсийн дарга Д.Гэрэлцэцэг, Нэг цэгийн үйлчилгээний байцаагч О.Хаш-Эрдэнэ, Тэтгэврийн хяналтын байцаагч, мэргэжилтэн Ч.Отгонтуяа, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны Сургалт, судалгааны төвийн багш М.Ганаа, Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбооны зөвлөх Б.Долоонжин, Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Соёл урлаг, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Б.Золжаргал, Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөр нийгмийн хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн О.Янжмаа, Нарийн бичгийн даргаар Хуулийн мэргэжилтэн Т.Төгсболд нар тус тус ажилаж байна.

Газрын дэрэгдэх Маргаан хянан шийдвэрлэх салбар шаардлагын зөвлөл 2 удаагийн хурлаар 5 даатгуулагчтай холбоотой асуудал хэлэлцсэнээс 2 иргэнд шийдвэрлэхээс татгалзаж 3 иргэнд шийдвэрлэн тогтоол гаргасан байна.

### **Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах ажлын талаар**

“Төрийн албаны тухай” хууль, “Хөдөлмөрийн тухай” хууль, “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд байгууллагын хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг зохион байгуулах, албан хаагчдын нийгмийн баталгаа, сургаж мэргэшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хүний нөөц, хөдөлмөрийн харилцаатай аливаа үйл ажиллагааг төлөвлөн шийдвэрлүүлэх, удирдлагыг мэдээллээр ханган ажиллахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

1.Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн мэдээллийн санд ажилтан албан хаагчдын албан тушаал, цалин, томилгоонд өөрчлөлт орсон тухай бүр хөдөлгөөн, өөрчлөлтийг бүртгэж, шилжин ирсэн 2, шилжин явсан 2, Хүүхэд асрах чөлөөний хугацаа дуусч ажилдаа буцаж томилогдсон 1, Жирэмсний болон амаржсны, хүүхэд асрах чөлөө авсан 1, богино хугацааны чөлөө авсан 2, ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтан, нэгж хооронд шилжин томилогдсон-4, өндөр насны тэтгэвэрт гарсан 1, шинээр ажилд орсон 7 албан хаагчийг тухай бүр бүртгэж оруулж, нийт ажилтны мэдээллийг тухай бүр шинэчлэн ажилласан.

2.Салбарын хэмжээнд ашиглагдаж буй программ болох ABLE дээр идэвхтэй ажиллаж буй 78, жирэмсний болон амаржсны амралттай, хүүхдээ асрах чөлөөтэй байгаа 7, чөлөөлөгдсөн 3, өөр албан газарт шилжин ажилласан 2 ажилтан нарыг тухай бүр мэдээллийг хөтлөн баяжуулж, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангаж ажилласан.

3.Нийслэлийн төр захиргааны байгууллагуудын ашигладаг ERP, Edos программ дээр ажилтны албан тушаалын өөрчлөлт тухай бүр мэдээллийг хөтөлж, өөрчлөн, баяжуулж байгаа бөгөөд нийт 120 ажилтан бүртгэснээс одоогоор 78 ажилтан идэвхтэйгээр тус программыг ашиглан ажиллаж байна. Хүний нөөцтэй холбоотойгоор Edos программд цахимаар 6 өргөдөл, гомдол ирснийг хугацаанд нь шийдвэрлэж хариуг хүргүүлсэн. Цаасан баримтаар 20 өргөдөл, гомдол ирснийг шийдвэрлүүлж, хариуг нь хугацаанд нь хүргүүлсэн. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100 хувийн гүйцэтгэлтэй.

4.Нийгмийн даатгалын ерөнхий газрын хүний нөөцийн программд бүртгэлтэй 78 ажилтны мэдээллийг тухай бүр оруулан Sicos программтай холбон, хөтлөн, баяжуулж ажилласан.

5.Нийгмийн даатгалын ерөнхий газар, IT Zone компанитай хамтран салбарын хэмжээнд шинээр нэвтрүүлж буй GREEN ERP хүний нөөцийн программд тус газарт



бүртгэлтэй нийт 98 албан хаагчийн /үндсэн ажиллаж буй ажилтан, нийгмийн даатгалын төлөөлөгч, эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүд, жирэмсний болон амаржсны амралттай, хүүхдээ асрах чөлөөтэй эхчүүд/ төрийн албан хаагчийн анкет, хувийн мэдээллийг /банкны данс, ажил эрхлэлтийн түүх, ээлжийн амралтын цикл, хуваарь, ирцийн мэдээ... гэх мэт/ албан хаагч тус бүрээр шинээр бүртгэж ажилласан. Албан хаагчийн цахим хувийн хэргийг өдөр тутамдаа хөтлөн, баяжуулж, шилжилт хөдөлгөөн, өөрчлөлтийг өөрчлөлт орсон тухай бүр шинэчлэн ажиллаж байна.

6.Тайлант хугацаанд газрын даргын хүний нөөцтэй холбоотойгоор 41-н тушаалын төслийг бэлтгэж, албажуулсан. /А тушаал-12, Б тушаал-29/

7.Тайлант хугацаанд хүний нөөцийн хөдөлгөөний мэдээг сар бүр гарган Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэн ажиллаж байна. Газарт хийгдэж байгаа хүний нөөцийн хөдөлгөөн нь: шилжин ирсэн 2, шилжин явсан 2, Хүүхэд асрах чөлөөний хугацаа дуусч ажилдаа буцаж томилогдсон 1, Жирэмсний болон амаржсны, хүүхэд асрах чөлөө авсан 1, богино хугацааны чөлөө авсан 2, ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтан, нэгж хооронд шилжин томилогдсон-4, өндөр насны тэтгэвэрт гарсан 1, шинээр ажилд орсон 7 албан хаагчийг тухай бүр бүртгэж оруулж, нийт ажилтны мэдээллийг тухай бүр шинэчлэн ажилласан.

Албан хаагчдын тоо, шилжилт хөдөлгөөний бүртгэлийг тухай бүр хүний нөөцийн программд /5-н программ/ бүртгэж, төрийн албан хаагчийн хувийн хэргийг цаасаар болон цахимаар баяжилтыг тухай бүр хийж, хадгалж байна.

8. Нийгмийн даатгалын салбарт үр бүтээлтэй ажилласан, ажил үйлсээрээ шалгарсан 5-н албан хаагч нарын шагналын материалыг дээд газарт хүргүүлэн ажиллаж байна.

9.Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан нийт албан хаагчдад бэлэг олгох ажлыг зохион байгуулсан.

10.Газрын нийт 78 ажилтны төрийн албан хаагчийн хувийн хэргийг Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлөөс баталсан журмын дагуу шинэчлэн цэгцэлж, баяжуулсан. Мөн ажилд шинээр томилогдсон, урт хугацааны чөлөөний хугацаа нь дуусаад ажилдаа эргэн орсон, ажилтны хувийн хэргийг шинээр баримт бичгийн бүрдлийн дагуу цуглуулж, үүсгэсэн. Мөн төрийн өөр байгууллагат шилжин ажилласан 2 албан хаагчийн хувийн хэргийг журмын дагуу хүлээлгэн өгсөн.

11.Газрын нийт ажилтантай холбоотой бүх төрлийн судалгааг харьяалагдаж буй нэгж бүрээр шинэчлэн гаргаж өдөр тутмын ажилдаа мөрдлөг болгон, удирдлагыг мэдээллээр ханган ажиллаж байна.

- Удирдах албан тушаалтнуудын судалгаа-1
- Хувийн хэргийн бүрдлийн судалгаа-1
- Ахмад настнуудын судалгаа-1
- Нийт албан хаагчдын цалингийн судалгаа-1
- Сул орон тооны захиалга-1 удаа
- Хяналт шалгалтын байцаагч нарын судалгаа-2
- Шинэ албан хаагчдын судалгаа-1
- Тангараг өргөх албан хаагчдын судалгаа-1
- Төрийн албаны сургалтын судалгаа-1
- Нийгмийн баталгааг хангах талаар санал, судалгаа-1
- Цалин хөлсний нэмэгдлийн талаар санал, судалгаа-1
- Орон тооны мэдээ, судалгаа-5
- НДЕГ-ын Зөвлөмжийн хэрэгжилтийг хэрэгжүүлэх албан бичгийн хүрээнд судалгаа, тайлан мэдээ-1
- ГБХНХСайдын 2 тушаалын хүрээнд хэрэгжилтийг ханган мэдээг хүргүүлсэн-2
- БЗДЗДТГаас хүний нөөцийн зохион байгуулалттай холбоотой ирсэн 5-н албан бичгийн хэрэгжилтийг зохион байгуулан тайланг гарган хүргүүлсэн.



12.Зэрэг дэв шинээр авах 5 ажилтан, зэрэг дэв нэмүүлэхээр 12 ажилтан нийт 17 ажилтны холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн холбогдох газарт хүргүүлсэн. Мөн нийт 75 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлийг олгосон.

13. 2024 оны 12 дугаар сард НДЕГ-т мэргэшлийн зэргийн судалгаа, зэрэг дэвийн судалгааг хүргүүлсэн. Гэр бүл, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/57 дугаар тушаалаар Тэргүүлэх мэргэшлийн зэрэг-5, зөвлөх мэргэшлийн зэрэг-4, итгэмжит зөвлөх мэргэшлийн зэрэг 10-н албан хаагч авч байна.

14.Тайлант хугацаанд шинээр ажилд орсон 7, шилжиж ирсэн 2 ажилтанд байгууллагын дотоодод дагаж мөрдөх дүрэм, журам, төрийн албаны тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалт, ажлын цаг ашиглалтын талаар ганцаарчилсан сургалтыг зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

15. GREEN ERP хүний нөөцийн программд тус газарт бүртгэлтэй нийт 93-н албан хаагчдаас идэвхтэй 78-н албан хаагчдад Sicos программд ажиллах хэрэглэгчийн эрхийг тухай бүр нээж өгч ажилласан.

16. Салбарын хэмжээнд ашиглагдаж буй программ болох ABLE дээр идэвхтэй ажиллаж буй 78-н албан хаагчийг тухай бүр GREEN ERP хүний нөөцийн программын кодтой давхцуулан ABLE программд кодыг бүртгэн, цагийн бүртгэлийн машинд холбуулан ажиллаж байна.

17. Тайлант хугацаанд хүний нөөцийн хөдөлгөөний мэдээг Нийслэлийн нийгмийн даатгалын газарт сар тутам нийт 5-н удаа, Нийгмийн даатгалын ерөнхий газарт 7-н удаа тус тус хүргүүлэн ажилласан бөгөөд орон тооны хэтрэлгүй ажиллаж байна.

18. Нийгмийн баталгааг хангах 3 зорилт, 14 ажил үйлчилгээ хөтөлбөрийн хүрээнд нийт 11-н албан хаагчид буцалтгүй тусламж олгосон. 30-н Ахмад настанд 1 удаа хүндэтгэл үзүүлэн урамшуулал олгосон. Удирдлагын академийн Ахлах түшмэлийн сургалтанд 2-н албан хаагч хамрагдах хугацаанд цалинтай чөлөө олгон дэмжин ажиллаж байна. Нийт албан хаагчдыг 2025 оны 02 дугаар сард өдрийн эмчилгээнд хамруулсан. Сэтгэцийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулсан. Байгууллагаас буцалтгүй тусламж нийт 5-н албан хаагчид олгосон. Удирдах албан тушаалтнуудаас газрын хэмжээнд давхардсан тоогоор нийт 34-н албан хаагч чөлөө авсан байна. Нийт албан хаагчдыг бие бялдрын сорилд хамруулсан.

19.Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газраас ирсэн нийт 5-н албан бичиг, захирамж, удирдамжийн хүрээнд олон нийтийг хамарсан цаг үеийн арга хэмжээнд бүх албан хаагчдаа хамруулан тайлан мэдээг гарган ажиллалаа.

20. ABLE программаар Нийгмийн даатгалын ерөнхий газраас хүний нөөцтэй холбоотой нийт 11-н албан бичиг ирснийг тухай бүр танилцан тайлан мэдээг гарган, хариуг хүргүүлсэн.

21. Тайлант хугацаанд шинээр ажилд орсон 7, шилжиж ирсэн 2 ажилтанд болон газрын нийт 78-н албан хаагчдад хүний нөөцийн программуудтай ажиллах ганцаарчилсан сургалтыг давхардсан тоогоор 108 албан хаагчдад зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Монгол бичгийг дунд шатны нийт 22-н удаагийн сургалтанд хамрагдан, суралцсан. Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулдаг Төрийн албаны вебинар сургалтанд долоо хоног бүр тогтмол хамрагдан, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль журмын талаарх мэдлэгээ дээшлүүлэн ажиллаж байна.

#### **Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, түүнд хяналт тавьж ажиллах**

Албан хаагчдын 2024 оны ХАСХОМ гаргах ажлыг Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/45 дугаар тушаал, үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан ХАСХОМ-1, ХАСХОМ-ийн 2024 оны тайлангийн маягт, Авлигатай

тэмцэх газрын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/122 дугаар тушаалын 3, 4 дүгээр хавсралтаар ХАСХОМ-2 маягтын дагуу 35 албан тушаалтан 2024 оны “ХАСХОМ” гаргаж 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр НДЕГ-т хүргүүлж ажиллалаа.

2025 оны эхний хагас жилийн байдлаар шүүхээр шийдвэрлүүлсэн маргаан, хэлэлцэгдэж байгаа дараах асуудлын талаар мэдээ, тайлан, судалгааг цаг хугацаанд хүргүүлж ажиллалаа.

Тухайлбал: Тэтгэвэртэй холбоотой асуудлаар Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 4 иргэний гомдолд хариуцагчаар оролцож 2 гомдлыг хэрэгсэхгүй болгуулж, 2 иргэний гомдлыг иргэний талд шийдвэрлүүлж ажилласан мөн нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг төлүүлэхээр 67 ААНБ-ын 5,199.5 сая төгрөгийн шимтгэл, 433.9 сая төгрөгийн алданги нийт 6,199.5 сая төгрөгийг төлүүлэх нэхэмжлэлийг хүргүүлж, 8 ААНБ-ын 4,660.8 сая төгрөгийн шимтгэл, 4.8 сая төгрөгийн алданги нийт 4,665.7 сая төгрөгийг албадан гаргуулахаар ШШГБ-д хүргүүлсэн.

ААНБ-ын хаяг тодруулах, эзэн холбогдогчийг эрэн, хайх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Цаашид хуримтлагдсан өртэй ААНБ-ын шимтгэлийг өр төлбөрийг барагдуулах талаар Шүүх, ШШҮБ, Прокурорын байгууллагуудтай нягт хамтран ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.

Газрын нийт албан хаагчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2 удаа (Авлигатай тэмцэх газрын СОНХХ, Баянзүрх дүүргийн цагдаагийн газар цахим гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс)-ийн сургалтыг хамтран зохион байгуулж ажиллалаа. Мөн мэдүүлэг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ) нарт зориулсан сургалтыг 1 удаа АТГ-ын хяналт, шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр 09:00-12:30 цагийн хооронд “Zoom” цахим сургалтад бүх албан хаагчийг хамруулж ажилласан.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд хөрөнгө орлогын мэдүүлэг хэрхэн мэдүүлэх талаар 1 удаагийн сургалтын зохион байгуулж 35 албан хаагч хамрагдсан байна.

## Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэргэжлийн болон үйлчилгээний ур чадварыг дээшлүүлж, мэргэшүүлэх чиглэлээр, сургалт сурталчилгаа

2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлт хосолсон бичгээр хөтлөгдөх болсонтой холбогдуулан Монгол бичгийн 60 цагийн сургалт, Нийгмийн даатгалын улсын байцаагч нарыг чадавхжуулах зорилтын хүрээнд Санхүү эдийн засгийн их сургуулийн зөвлөх багш Ч.Өнөржаргал “Нягтлан бодох бүртгэлийн ойлголт, санхүү, татварын тайланд анхаарах асуудлууд” сургалт зэрэг нийт 25 удаагийн сургалт мөн шинээр томилогдсон албан хаагчдад зориулан 7 удаагийн чиглүүлэх, мэдлэг чадвар



эзэмшүүлэх ганцаарчилсан сургалтыг тогтмол зохион байгуулж ажилласан мөн Хувь





хүний хөгжил, мэдлэг чадвараа дээшлүүлэх сургалтаар “Байгууллагын соёл ба үнэт зүйл”, “Хувь хүний хөгжил, бүтээлч хандлага” болон Стресс менежмент ажлаас халшрах хам шинж сэдэвт 6 удаагийн сургалтуудыг тус тус зохион байгуулж ажилласан.

Тухайлбал: Газрын албан хаагчдын жилийн сургалтын хэрэгцээг тодорхойлж сургалтын хэрэгцээнд үндэслэн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулж дараах сургалтуудыг зохион байгуулан ажилласан байна. Хагас жилийн байдлаар байдлаар нийт 40 удаагийн сургалтад хамрагдсан байна Үүнд:



Нийгмийн даатгалын газрын ажилтан, албан хаагчдын харилцаа хандлага, бүтээлч байдал,



байгууллагын соёлыг төлөвшүүлэх зорилгын хүрээнд “Хөгжлийн менежмент” сургалт,

судалгааны төвтэй хамтран танхимын сургалт зохион байгууллаа.

. Нийгмийн даатгалын багц хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, нийт 5279 даатгуулагчид хүрч ажиллалаа. Үүнд:

-Баянзүрх дүүргийн 1, 5, 18, 20, 30, 41, 43 дугаар хороодын малчид, ШШГЕГ-ын

харьяа хорих ангиудад, зах худалдааны төвүүд болох





нийт 15 удаагийн сургалтаар 3176 иргэнд зөвлөгөө, мэдээлэл хүргэв.

**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР**

Нийгмийн даатгалын багц хууль болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн талаар Дотоод Хэргийн их сургуульд сургалт хийлээ.

Алба хаагчдын цэргийн тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн даатгалын шимтгэлийн ач холбогдлын талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Тэтгэврийн хяналтын байцаагч Д.Ангарал, Хамралт орлого хариуцсан байцаагч Ган-Өлзий, сургалтын мэргэжилтэн С.Мөнхсана нар "Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль", "Нийгмийн даатгалын ерөнхий хууль" сэдвээр сургалтад алба хаагчдыг хамрууллаа. Энэ үеэр харилцан ирлцж, зөвлөгөө мэдээллийг өгч, шийдвэрлэх арга замыг тодорхойлсон үр дүн бүхий сургалт боллоо.




-Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 18 байгууллагын 2103 даатгуулагчдад

Эдгээр байгууллага, нэгжүүдтэй хамтран хууль сурталчлах ажлыг амжилттай зохион байгуулсан болно.

**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР**

ШШГЕГ-ын харьяа "400 ДҮГЭЭР НЭЭЛТЭЙ, ХААЛТАЙ ХОРИХ АНГИ"-ТАЙ ХАМТРАН, НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАГЦ ХУУЛИЙН АЧ ХОЛБОГДЛЫГ ТАНИУЛАХ СУРГАЛТЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЖ АЖИЛЛАЛАА.

- Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон түүний талаарх ерөнхий ойлголт;
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль;
- Нийгмийн даатгалд сайн дурар даатгуулах, түүний ач холбогдол, гэрээ байгуулах тухай.

Сургалтад нийт 93 алба хаагч оролцож, тэдгээрийн сонирхсон асуултад хариулт өгч, санал хүсэлтийг хүлээн авч ажиллалаа.





Сургалтыг нэг хөрөн - үйлчилгээний байрлалд С.Биебажарал, Сайн дурын даатгал хариуцсан байцаагч Б.Мөнх нар зургаан нүрхтэй алба хаагчид гарцан мэдэл олгох зорилгоор сургалтыг зохион байгуулсан юм. 2025.03.27

**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР**

Даатгуулагчийг дэмжих жил-ийн хүүрнэнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа "Ангалан" мэргэжлийн боловсролын сургуулийн газарт сургалт зохион байгууллаа.

Алба хаагчдын цэргийн тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн даатгалын шимтгэлийн ач холбогдлын талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор нэг цэргийн зөвлөгөө мэдээллийн байцаагч С.Биебажарал, сайн дурын даатгал хариуцсан байцаагч Д.Мөнхөө, сургалтын мэргэжилтэн С.Мөнхсана нар "Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль", "Нийгмийн даатгалын шимтгэл, түүний ач холбогдол" сэдвээр сургалтад алба хаагчдыг хамрууллаа.





**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР**

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА**

Нийгмийн даатгалын тухай ойлголт, ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилгоор **Тогтун Фүүд ХХК-ийн** ажил олгогч болон ажилчдад зориулсан сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Сургалтын үеэр Нийгмийн даатгалын ерөнхий хууль, ажил олгогчийн эрх, үүрэг, даатгуулагчийн нийгмийн баталгааг хангахад шимтгэлийн ач холбогдол, сайн дурын даатгалын боломжууд зэрэг сэдвүүдийг дэлгэрэнгүй танилцуулж, оролцогчдын асуултад хариулт өгч, зөвлөгөө мэдээлэл хүргэлээ.







**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР**

“Баянзүрх эмнэлэг ХХК”-ийн хамт олонд “Нийгмийн даатгалын багц хууль”-иар болон Тэтгэвэр, тэтгэмжинд хамрагдах нөхцөлүүдийн талаарх сургалт, мэдээлэл хүргэн ажиллалаа.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2025 оныг “Даатгуулагчийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан, иргэд, даатгуулагчид болон хамтран ажиллагч байгууллагуудад чиглэсэн сургалт, мэдээллийн ажлуудыг шат дараатай зохион байгуулж байна.

Энэ хүрээнд ШШГЕГ-ын харьяа хорих 407 дугаар нээлттэй, хаалттай ангийн ажилтан, алба хаагчид болон тус ангид хүмүүжж буй хүмүүжүүлэгчид зориулсан нийгмийн даатгалын багц хуулийн талаарх сургалт, мэдээлэл хүргэлээ.

Сургалтаар: Нийгмийн даатгалын багц хууль, цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай ойлголт, Сайн дурын даатгалын ач холбогдол, даатгалд хамрагдах боломж зэрэг чухал мэдээллийг хүргэж, оролцогчдын сонирхсон асуултад хариулт өгч ажиллалаа.






**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР**

БЗД-ын Санхүү төрийн сангийн хэлтсээс зохион байгуулсан төсвийн Байгууллагуудын нэгтгэн бодогч нарын мэдлэг, үр чадварыг дээшлүүлэх сургалтад Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлт Тайлан, шингэлт төлөөллийн талаарх сургалтыг

Тогтун Фүүд ХХК-ийн ажил олгогч болон ажилчдад зориулсан сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Сургалтын үеэр Нийгмийн даатгалын ерөнхий хууль, ажил олгогчийн эрх, үүрэг, даатгуулагчийн нийгмийн баталгааг хангахад шимтгэлийн ач холбогдол, сайн дурын даатгалын боломжууд зэрэг сэдвүүдийг дэлгэрэнгүй танилцуулж, оролцогчдын асуултад хариулт өгч, зөвлөгөө мэдээлэл хүргэлээ.





**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР**

**“ДААТГУУЛАГЧИЙГ ДЭМЖИХ ЖИЛ”-ИЙН ХҮҮРЭНД ЭЭЛЖИТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА**

Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2025 оныг “Даатгуулагчийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан, иргэд, даатгуулагчид болон хамтран ажиллагч байгууллагуудад чиглэсэн сургалт, мэдээллийн ажлуудыг шат дараатай зохион байгуулж байна.

Энэ хүрээнд ШШГЕГ-ын харьяа хорих 407 дугаар нээлттэй, хаалттай ангийн ажилтан, алба хаагчид болон тус ангид хүмүүжж буй хүмүүжүүлэгчид зориулсан нийгмийн даатгалын багц хуулийн талаарх сургалт, мэдээлэл хүргэлээ.

Сургалтаар: Нийгмийн даатгалын багц хууль, цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай ойлголт, Сайн дурын даатгалын ач холбогдол, даатгалд хамрагдах боломж зэрэг чухал мэдээллийг хүргэж, оролцогчдын сонирхсон асуултад хариулт өгч ажиллалаа.









2 удаагийн Шууд лайв ярилцлага, Сайн дурын даатгал болон, Шимтгэлийн хувь хэмжээ, ажил олгогч, даатгуулагчийн эрх үүрэг сэдвээр мэдээлэл хүргэж нийт 7900 хүнд хүрч

–Мэдээллийн пост **74** удаа

–Богино хэмжээний **рийл бичлэг – 33** удаа

–**Фото мэдээ, постер – 24** удаа нийтэлж 1217014 үзэлт хандалтыг авсан байна. Мөн



Нийгмийн даатгалын ерөнхий газар болон ГБХНХЯ-ны Page хуудсаар нийтэлсэн мэдээллийг тогтмол хуваалцан түгээж, цахим орчны идэвхийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

Цахим орчин дахь мэдээлэл түгээх ажлыг шат дараатай хэрэгжүүлсний үр дүнд Page хуудсыг дагагчдын тоо 2669-аар өссөн үзүүлэлттэй байна.

13. Тус газрын байцаагч, ажилтнуудыг чадавхжуулах, мэргэшүүлэх ажлын хүрээнд нийгмийн даатгалын багц хуультай нийцүүлж гаргасан НДҮЗ-ийн тогтоол, ЗГ-ын тогтоол, сайдын тушаал, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан дүрэм журам, зааврыг багтаасан цахим гарын авлагыг боловсруулан 2025 оны эхний хагас жилд багтаан байцаагч, ажилтнуудын өдөр тутмын хэрэглээнд нэвтрүүлэхээр төлөвлөж ажиллаж байна

14. Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын газар нь иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэж ажиллахдаа мэдлэг, чадварт суурилсан төрийн үйлчилгээг үзүүлэх зорилтыг 2025 онд дэвшүүлэн ажиллаж байна.

Энэхүү ажлын хүрээнд байцаагч ажилтнуудад хууль, тогтоомжийн талаар 7 хоногт 01:30 цагийн сургалтыг хэлтсийн дарга нар болон холбогдох мэргэжилтнүүд нийт 6 удаагийн хичээлээр нийгмийн даатгалын багц хууль болон түүнтэй нийцүүлж гаргасан дүрэм журмыг хэрэгжүүлэх талаар мөн нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулж байгаа цахим сургалтад хэлтэс (тасаг) бүрээр хамруулан ажилтнуудын мэдлэгийг нэмэгдүүлэх ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

#### **Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах**

Мэдээлэл технологийн ашиглалтыг сайжруулах программ хангамжийн ажил үүргийн тохиргоог байцаагч бүрээр бүртгэх баталгаажуулах, нэвтрэх нэр, нууц үг, эрхийн тохиргооны талаар 1 удаагийн сургалтыг зохион байгуулж, бүртгэл хяналтын картыг албан хаагч бүрээр хөтлөн ажиллаж байна.

\*Шинээр томилогдсон албан хаагчдад ганцаарчилсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, мэдээллийн технологийн ашиглалт сэдвээр 3 удаагийн сургалтын зохион байгуулж ажилласан.

\*Мэдээллийн технологийн ашиглалтад тогтмол хяналт тавьж эрхийн тохиргоог газар, хэлтсийн даргын зөвшөөрлөөр албан тушаалтан бүрээр хяналтын карт хөтлөн гарыг үсэг зуруулан олгож хэвшсэн.

Сүлжээнд холболтын хэвийн ажиллагааг сар бүрийн 5 ны дотор буюу 2025 оны эхний улирлын байдлаар 5 утасанд давтагдсан тоогоор нийт 25 удаа хийж гүйцэтгэсэн.

Программын ажил үүргийн тохиргоог хариуцан ажилладаг бөгөөд сэлгэн ажилласан 7, шилжин явсан 2, шинээр ажилд томилогдсон 7 албан хаагчийн тохиргоог хийж ажилласан. Мөн Шинээр томилогдсон албан хаагчдад ганцаарчилсан сургалтыг Мэдээллийн технологийн ашиглалт сэдвээр 3 удаа зохион байгуулсан.

Программын эрхийн тохиргоог хийх, шинээр тохируулах ажлыг хариуцан ажилладаг бөгөөд 2025.04.15- 2025.06.01 хооронд шалгалтаар ирсэн 3 байцаагчид түр акт үйлдэн тэтгэмжийн байцаагчийн эрх олгосон, байцаагчийн ажил үүргийн хуваарийг улирал бүр шалгадаг бөгөөд 2, 5 дугаар саруудад тус бүр нэг нэг удаа шалгасан

Дээрх хугацаанд 13 компьютерт засвар үйлчилгээ хийж, үйлдлийн системийг шинэчлэн тохиргоо хийж хэрэглээний 8 багц программ хангамжийг суулгасан.



Тэтгэврийн хувийн хэрэг цахимжуулах ажлын хүрээнд i5 CPU, 8GB RAM бүхий 2 иж бүрэн компьютерыг ашиглалтад оруулж 202 тоот өрөөнд суурилуулсан. Мөн 2 төрлийн 6 ширхэг сканнер төхөөрөмжийг 202 тоот өрөөнд 2ш, 203 тоот өрөөнд 2ш, 302 тоот өрөөнд 2ш-ийг хоболт хийсэн.

Дээрх ажилтай холбогдуулан 8 TB /terabyte/ их багтаамж бүхий дата HDD хадгалах төхөөрөмж 2 ширхэгийг худалдан авч 1 ширхэгийг нь дундын серверт байршуулж 1 ширхэгийг нь хөдөлгөөнгүй хадгалах /backup data/ диск болгон байршуулсан.

2019 онд НДЕГ-аас хүлээлгэн өгсөн архивын сканнерыг 2025 оны 03 сарын 29-нд эргэн ашиглалтанд оруулж 302 тоот өрөөнд дотоод сүлжээнд холбон тохиргоог хийж суурилуулсан

НДЕГ-ын удирдамжийн дагуу шалгалтаар ирсэн 3 албан хаагчид 3 ширхэг суурин компьютерын сургалтын танхимд байршуулан ажиллах нөхцөл, программын эрхээр ханган ажилласан

Сервер компьютерт үзлэг хийж байгууллагын дотоод сүлжээний доголдлыг арилгахаар 2025.02.08-09 ний өдрүүдэд ажиллаж давхар хоорондын свич, төв шугам зэргийг шалгаж завсарыг амжилттай хийж дуусгасан.

203 тоот өрөөний дотоод свич доголдсоныг үзэж шалгаад хуучин свичээр түр орлуулан тавьж сүлжээг сэргээж ажилд оруулсан. /Цаашид свич шинэчлэх шаардлагатай/

202 тоот өрөөнд Network HUB байрлуулж тэтгэврийн архив цахимжуулах 2 компьютерыг дотоод сүлжээнд холбосон

Газрын хэмжээнд дотоод сүлжээнд нийт албан хаагчдын дунд хандалтын нээлттэй өгөгдлийн бааз үүсгэх зорилгоор DELL 7050 – i7 загварын 1TB HDD диск, 16GB RAM бүхий компьютерыг байрлуулсан бөгөөд \\10.10.6.130 гэсэн тогтмол протокол үүсгэн 2025 оны 03 сарын 29-ны өдрөөс ажиллуулж эхэлсэн. /Тухайн компьютерын хүчин чадлыг цаашил нэмэгдүүлэх шаардлагатай. /

8 TB /terabyte/ их багтаамж бүхий дата HDD хадгалах төхөөрөмж 1 ширхэгийг нь дундын серверт байршуулж Тэтгэврийн цахим хувийн хэргийг байршуулахад бэлэн болсон байна.

Дохиолол хамгаалалтын “Бамбай секьюрити сервис” ХХК-ны ажилтнуудтай хамтран дохиоллын самбар, дуут түгшүүрлэгч, хяналтын камер зэрэгт 2025.01.24-ий өдөр үзлэг хийж ажиллахгүй байсан 5 камерын тохиргоог хийж хэвийн ажиллагаанд оруулсан

Дохиолол хамгаалалтын түгшүүр дамжуулах мэдээллийн процессор /төв саибарын/ эх хавтан шатаж ажиллагаагүй болсныг 2025.05.13-нд холбогдох инженер техникын ажилтнуудад дуудлага өгч засвар үйлчилгээг хийлгэн доголдлыг арилган ажилласан. Эх хавтан 550,000₮ -өөр шинээр солих ажил хийгдсэн

МТТ-өөс ирүүлсэн программтай холбоотой 1 гарын авлагыг нийт албан хаагчдад хүртээмжтэй байдлаар дундын хавтсанд байршуулсан, Мөн РД-ын алдаатай байсан иргэдийн мэдээллийг засах жагсаалтыг ХОХ-ийн дарга Б.Түвшинзаяа, байцаагч Н.Сайнбаяр нарт дамжуулан хариуг тухай бүр мэдэгдэн ажилласан.

**ТАЙЛАНГ ХЯНАСАН: ДАРГА**

**Ш.АРИУНТУЯА**

**ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН: МЭРГЭЖИЛТЭН**

**Б.ӨНӨРБУЯН**